



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 4/08

Булган сум

**“Залуусын хөгжил” хөтөлбөрийг боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Залуусын хөгжил” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Мягмаржаргал (Аймгийн Засаг даргын зөвлөх)
	Б.Энх-Эрдэнэ (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч)
	Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам, нийгмийн бүлгүүдийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
	Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
	С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Урантөгс (Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан мэргэжилтэн)
	Б.Дүүрэнбаяр (Аймгийн Залуучуудын зөвлөлийн тэргүүн)
	Э.Манлайбаатар (Аймгийн Залуучуудын холбооны тэргүүн)
Нарийн бичгийн дарга:	М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Залуусын хөгжил” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сүхбаатар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

03-5010173